



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 4/225

Улаанбаатар хот

**Б.Буяннэмэхийг туршилтын
хугацаагаар ажилд томилох тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 28 дугаар зүйлийн 28.3, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 20 дугаар зүйлийн 20.3, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 05/4417 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Болдбаатарын Буяннэмэхийг Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Говь-Угтаал сумын улсын бүртгэгчээр 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 6 сарын туршилтын хугацаагаар томилон ажиллуулсугай.

2.Б.Буяннэмэхт 410 дугаартай улсын бүртгэгчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.


3.Б.Буяннэмэхийн Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээхийг Иргэний улсын бүртгэлийн газар /Г.Нармандах/-т даалгасугай.

4.Албаны нууцтай танилцах эрх олгон, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулахыг нууц хамгаалах ажилтан /Б.Сайхантуяа/-д үүрэг болгосугай.

5.Б.Буяннэмэхийн албан тушаалын цалинг төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-6-1-т хамааруулж, хоол унааны нөхөх зардлыг холбогдох журмын дагуу тус тус тооцон олгохыг Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Сайхантуяа/-т зөвшөөрсүгэй.

6.Б.Буяннэмэхийн үүрэгт ажлыг зохих журмын дагуу хүлээлцэхийг Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Сайхантуяа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571201335